



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/60

Аргатай

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 тоот тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.5, 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын тамгын газар, ахмадын байрны барилгын халаалтын системд урьдчилан тооцоолох боломжгүй, цаг үеийн шинжтэй давагдашгүй хүчин зүйл, нөхцөл байдлын улмаас гэмтэл гарч засвар үйлчилгээг нэн яаралтай гүйцэтгүүлэх шаардлагатай болсон тул сангийн иж бүрэн засварын ажил гүйцэтгүүлэх зардалд 3.000.000 (гурван сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Засварын ажлыг цаг алдалгүй, чанартай гүйцэтгүүлэн, халаалт зогссоноос болж гарч болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлж, бүх албан хаагчдыг бэлэн байдалд ажиллуулахыг Засаг даргын орлогч (А.Отгонсүрэн), Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Отгонбаатар) нарт үүрэг болгосугай.

3. Дээрх ажлын зардалд шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Отгонбаатар), нягтлан бодогч (А.Цогзолмаа)-д тус тус зөвшөөрсүгэй.

ДАРГА



Р.УУГАНБААТАР